

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны ... сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Даатгалын компанийн дүрмийн сангийн
доод хэмжээг тогтоох” тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1 дэх заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 5 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 6 тэрбум төгрөг, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 15 тэрбум төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Хорооны 2012 оны 355, 2016 оны 236 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН